

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Арилдийн Шагдарсүрэн	Дугаар	L129
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Наран
Төрсөн газар	Наран	Төрсөн он	1925
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Гүн худгийн хийд, Талын модонгийн хийд	Сүм хийдийн дугаар	СБНР 013, СБНР 011
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 26	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Наран сумын Гүн худгийн хийд, Талын модонгийн хийд

-Цагаан нуур чинь Наран сумын нутаг уу?

Манай нутаг аа.

-Тэр хийд нь хаанаа байсан юм бол?

Ухаагийн энгэрт байдаг.

-Тэгээд одоо танай сүмд тэмдэглэгдсэн энэ хийдүүдийнхээ тухай арай дэлгэрэнгүй зүйл асууж ярилцмаар байна? Хэр олон ламтай байсан? Хэдэн дугантай байсан гээд?

Би тэр сүмд бол байгаагүй хүн шүү дээ. Гүн худаг гэдэг бол манайхны бригадын төв байсан тэнд сайхан сүм байсан.

-Энэ хийдүүдэд сууж байсан лам нарын тухай болон энэ тухай өөрийн сонссон дуулсан зүйлээ хэлж өгөөч?

Гүн худаг гэдэг чинь сайхан сүм байсан. Сайн худаг гэдэг чинь том хийд байсан. Талын модон гэдэг чинь сайхан сүм байсан юм. Урьдын лам нар нь сайн сайн лам нар байсан.

-Хийдээс тодорч байсан хувилгаад хутагт байсан уу? Байсан бол ямар ямар хүмүүс байсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ямар хувилгаан байсан юм мэдэхгүй. Хувилгаан гэж ярьдаггүй л юм. Санжаа гэвш гэж Гүн худгийн сайн лам байсан Бурхан Санжаа гэдэг байсан. Баригдаагүй нас барсан.

-Наад хийдүүдэд нь олонд алдаршсан сайн лам нар байсан болов уу?

Тэрийг би сайн мэдэхгүй байна. Онгон сумын Орилоо Дорждэрэм гэж байгаа.Тэр хүн тэр хавиа сайн мэднэ дээ.

-Сөдөтийн хийд маань яг ямар нэртэй газар байна вэ?

Сөдөтийн хийд гэж Цагаан нуурын зүүн хойшоо Хөндлөн ухаагийн энгэрт байсан түүрх бараг байхгүй болсон байгаа ором нь л байгаа.

-Талын Модонгийн сүм чинь ямар газар байгаа вэ?

Баруун урагш.

-Гүн худаг нь хаана?

Ринцэндэрэм, Эрдэнэ Өлзийт гэдгийн нэр. Ринцэндэрэм гэдэг тахидаг сайхан хад байгаа.

-Сайн худгийнх нь хийд нь хаана вэ?

Сайн худгийн хийд гэж байсан газар одоо 5-р застав байгаа.